



**БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ**

**2025 ОНЫ 02 ДУГААР
САРД ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

СӨҮЛ ХОТ

2024 оны 03 дугаар сарын 11-ний өдөр

Тайлант хугацаанд чиг үүргийн хүрээнд дараах үйл ажиллагааг явуулж ажилласан.

- I. АЖИЛЛАХ ХҮЧ ИЛГЭЭХ САНАМЖ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ
- II. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТ
- III. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ

I. АЖИЛЛАХ ХҮЧ ИЛГЭЭХ САНАМЖ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ

1. БНСУ-д Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдэд дэмжлэг үзүүлэх, мэдээллийн санд баяжилт хийх арга хэмжээ

1.1.1 Хөдөлмөрийн гэрээт ажилчны Е-9 визээс ур чадвартай ажиллах хүчний Е-7-4 виз рүү шилжсэн иргэдийн судалгаанд тайлант хугацаанд 10 иргэнийг, тус виз рүү шилжих хүсэлтэй болон хугацааны болзол хангасан иргэдийн судалгаанд 3 иргэнийг шинээр бүртгэж, нийт 13 иргэд оноо тоолох, гэр бүлээ урих, хэлний шалгалт сургалтад бүртгүүлэх, визний ангиллаа дараагийн ангилал руу өөрчлөх талаар мэдээлэл, зөвлөгөө өгч 6 иргэнд сургалтын материал, жишиг тест болон солонгос хэлний ном товхимлыг хүргүүлсэн.

1.1.2 БНСУ-д ажиллаж, амьдарч буй монгол иргэдийн судалгаа, 2024, 2025 онд тус улсад гэрээгээр ирсэн иргэдийн тоон мэдээллийг гаргасан. Мөн Гимпо, Гимхэ хотуудад ажиллаж буй хөдөлмөрийн гэрээт ажилчдын тоон мэдээллийг гаргасан.

2. БНСУ-д оршин сууж байгаа монгол иргэд, гэр бүл, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгааг шинэчлэх, сэтгэл зүйн тулгамдсан асуудлаар үйлчилгээ үзүүлэх арга хэмжээ

1.2.1 Монгол иргэд, өрх, гэр бүлийн аж байдал, гэр бүлийн харилцааны нөхцөл байдлыг тодруулах зорилгоор ГБХНХЯ-ны захиалгаар “Хилийн чанад дахь монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, өөрчлөлт” судалгааны хамралтад дэмжлэг үзүүлэн ажиллаж, БНСУ-д ажиллаж амьдарч буй 110 иргэнийг судалгаанд хамруулсан.

1.2.2 БНСУ дахь Монгол сургуулийн 75 сурагчийг хамруулан “Дэлгэцийн хамаарал” сэдвээр 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдөр сургалт зохион байгуулж, гэр бүл, хүүхдийн асуудлаар хууль зүйн мэдээлэл хүргэн, сэтгэл зүйн зөвлөгөө өгч ажилласан.

1.2.3 Тайлант хугацаанд сэтгэл зүйн зөвлөгөө ганцаарчилсан сэтгэл засал нийт 17 хүнд хийж, сэтгэл зүйн зөвлөгөө өгсөн. БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр 2024 оны 12 дугаар сар болон 2025 оны 01 дүгээр сард ирсэн 12 иргэнд утсаар сэтгэл зүйн байдлыг тодорхойлж, ажиллаж байгаа үйлдвэр, амьдрах орчны талаар ярилцаж, мэдээлэл зөвлөгөө өгсөн.

1.2.4 Нийгмийн хамгааллын үйлчилгээний ажлын хүрээнд БНСУ-д хууль бусаар ажиллаж амьдарч буй иргэдийг эмнэлгийн үзлэг болон эрүүл мэндийн даатгалд хамруулах зорилгоор “JUBILEE” эрүүл мэндийн сайн дурын сантай хамтран ажиллаж, 2025 оны 02 дугаар сарын 16-ны өдөр дотор, чих хамар хоолой, сэргээн засах болон уламжлалт эмчилгээ, ерөнхий шинжилгээ, хөлийн венийн судасны өргөслийг оношлох, томуугийн вакцин, эмэгтэйчүүдийн нарийвчилсан үзлэг, эмийн үнийн хөнгөлөлт зэрэгт 8 иргэнийг хамруулж, нийт 1,700,000.00 воны эрүүл мэндийн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлсэн.

II. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

1. БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа болон бусад хэлбэрээр ажиллаж, амьдарч байгаа иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалд албан журмаар болон сайн дураар хамруулах нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх арга хэмжээ

2.1.1 БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд албан журмаар 16 иргэнийг хамруулж, холбогдох программд мэдээллийг бүртгэн гэрээ байгуулсан. Мөн Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээний хугацааг сунгаж 28 иргэн, гээж үрэгдүүлэн дахин авах хүсэлт гаргасан 7 иргэн, шинээр чөлөөлөгдөх гэрчилгээг 9 иргэнд тус тус олгосон.

2.1.2 БНСУ-д хөдөлмөрийн гэрээнээс бусад төрлийн визний ангиллаар оршин сууж буй Монгол Улсын 24 иргэнийг нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулан, холбогдох программд мэдээллийг бүртгэж гэрээ байгуулсан. Мөн Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээний хугацааг сунгаж 43 иргэн, гэж үрэгдүүлэн дахин авах хүсэлт гаргасан 26 иргэн, шинээр чөлөөлөгдөх гэрчилгээг 16 иргэнд тус тус олгосон.

2. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, тайлагнах арга хэмжээ

2.2.1 Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны А/01 дугаар тушаалаар тус тасгийн 2025 оны орлогын батлагдсан төлөвлөгөө 5,031,634,000.00 төгрөг, сар бүрийн орлогын төлөвлөгөө 419,302,833.33 төгрөг болно. Тайлант хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 54 хувиар биелүүлсэн.

Хүснэгт 1: Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төвлөрүүлэлт

Сар	Сарын орлогын төлөвлөгөө /төгрөгөөр/	Тэтгэврийн даатгалын шимтгэлийн орлого		Сайн дурын даатгалын шимтгэлийн орлого	Нийт төвлөрүүлсэн шимтгэлийн орлого		Биелэлтийн хувь	Тухайн сарын МБ-ны эхний өдрийн хаалтын ханш
		Вон	Төгрөг	Төгрөг	Вон	Төгрөг		
2	419,302,833.33	41,180,000.00	98,008,400.00	128,864,004.00	41,180,000.00	226,872,404.00	54	2.38

2.2.2 Тайлант хугацаанд 225,616,593.65 төгрөгийн шимтгэлийн орлогыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Төрийн сангийн дансанд төвлөрүүлэн, сарын мэдээг заасан хугацаанд гаргаж, мөн “Нийгмийн даатгалын ерөнхий хууль” болон “Шилэн дансны хууль”-д заасны дагуу Сангийн яамны холбогдох мэдээллийн санд байршуулсан.

III. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ

1. БНСУ-д амьдарч буй иргэд болон хөдөлмөрийн гэрээт иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгөх, өргөдөл гомдлыг шийдвэрлэх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах, гадаад хамтын ажиллагаа, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээ

3.1.1 Тайлант хугацаанд Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжууд, Үндэсний тэтгэврийн даатгалаас буцаан олголт авах, Солонгос Улсын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, ажил олгогч эзэд болон холбогдох бусад байгууллагуудтай харилцан зөвшилцөх, эвлэрүүлэн зуучлах, гомдол барагдуулах, орчуулга хийх, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх зэргээр утас, цахим, танхимаар нийт 860 удаагийн үйлчилгээг үзүүлсэн.

Хүснэгт 2: Үйлчилгээ үзүүлсэн иргэдийн тоо

Үйлчилгээ үзүүлсэн тоо	Утсаар	686
	Цахимаар	74
	Танхимаар	100
	Нийт	860

БНСУ-д оршин сууж буй иргэдэд хөдөлмөрийн харилцаатай холбоотой өргөдлийг хүлээн авч, Самсунг даатгалын оршин суух хугацаа дуусгавар болсны даатгал, үйлдвэрээс авах 13 дахь сарын цалингийн зөрүү, нутаг буцах зардал, үйлдвэрлэлийн ослын даатгал, олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс зэрэгтэй холбоотой 49 өргөдөл гомдол хүлээн авч нийт **155,351,637.00** воныг олгуулсан бөгөөд одоогийн байдлаар 7 өргөдөл гомдол шийдвэрлэх шатанд явагдаж байна.

Хүснэгт 3: Ажил үйлчилгээний төрлөөр иргэдэд олгуулсан нийт мөнгөн дүнгийн жагсаалт

Ажил үйлчилгээний төрөл		Мөнгөн дүн /вон/
Хөдөлмөрийн	Буцах замын зардал	10,537,000.00

гэрээт ажилчид	Цалин, илүү цагийн хөлс	2,738,435.00
	Самсунг даатгал дахь 13 дахь сарын цалин	86,130,325.00
	Үйлдвэрээс авах 13 дахь сарын цалин	25,703,077.00
	Үйлдвэрлэлийн ослын даатгал	10,932,800.00
Бусад төрлийн виз	Олгогдоогүй, хойшлогдсон цалин хөлс	7,140,000.00
	Үйлдвэрлэлийн ослын даатгал	
Хууль бусаар оршин суудаг иргэдэд	Олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс	10,582,000.00
	Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад	1,588,000.00
НИЙТ ОЛГУУЛСАН ДҮН		155,351,637.00

Хүснэгт 4: Өргөдлийн шийдвэрлэлтийн байдал

Хүлээн авсан өргөдөл, гомдол	Өргөдлийн шийдвэрлэлтийн байдал				Шийдвэрлэлийн хувь
	Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтэрсэн	Хугацаанд нь шийдвэрлэсэн	
49	42	7	-	42	85,71%

Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан болзол нөхцөлийг хангасан 4 даатгуулагчдад тэтгэмжийн тодорхойлолт олгосон.

Мөн тус төвд ирүүлсэн 2 иргэний өргөдлийг хүлээн авч, хуульд заасан хугацааны дагуу 100% шийдвэрлэн ажилласан.

3.1.2 ЭСЯ-ны Консулын хэлтэс, Төрийн банк, Хаан банктай хамтран “Явуулын үйлчилгээ”-г 2025 оны 02 дугаар сарын 15-ны өдөр Гуанжү хотноо ажиллаж, амьдарч буй монгол иргэдэд үзүүлсэн. Уг арга хэмжээний үеэр 16 иргэнд нийгмийн даатгалын хууль тогтоомжийн мэдээллийг биечлэн өгч, 3 иргэнийг сайн дурын даатгалд хамруулан, өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн 3 иргэнд ажилласан жил тооцох, өндөр насны тэтгэвэр тогтоолгох тухай зөвлөгөө өгч, 50 иргэнд сурталчилгааны материал тарааж ажилласан.

3.1.3 Төвийн БНСУ дахь “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв” сошиал хуудсанд 12 удаа, байгууллагын <https://seoulcenter.mlsp.gov.mn> цахим хуудсанд 11 удаагийн мэдээлэл, зөвлөгөө нийтэлж сурталчилснаар 92,194 хандалт авсан. “Хилийн чанад дахь монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, өөрчлөлт” судалгааны мэдээллийг төвийн цахим хуудас болон бусад олон нийтийн сүлжээгээр сурталчилж 90 удаа хуваалцсанаар 8,104 хүнд мэдээлэл хүргэв. Мөн судалгаанд хамрагдахыг уриалж 900 хүнд масс мессеж илгээн Монгол тауны хоол, худалдаа үйлчилгээний газруудад судалгааны талаарх зурагт хуудсыг байршуулж судалгааны явцын талаарх мэдээллийг өдөр тутамд хүргүүлэн ажилласан.

2. Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хүний нөөцийг чадавхжуулах, төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах арга хэмжээ

3.2.1 Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хүний нөөцийн албан хаагчдын сургалтад хамрагдсан. Төвийн 2016-2023 оны архивын баримт бичгийг холбогдох газруудад хүлээлгэн өгсөн.

3.2.2 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний тасгийн 2025 онд хэрэгжүүлэх ажлын нэмэлт төлөвлөгөөг боловсруулан батлуулж мөн “Үйлдвэрлэлийн ослын нөхөн төлбөрийн даатгалын тухай хууль”-ийг солонгос хэлнээс монгол хэл рүү хөрвүүлэн орчуулсан.

3.2.3 Төвийн чатбот системийн мэдээллийг шинэчлэн, хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна.